



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

“Мах” бондын зарим барьцаа
хөрөнгийг чөлөөлөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жаст Агро” ХХК-иас гаргасан 12 сарын хугацаатай, жилийн 16.2 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт арилжигдсан 439,954 /дөрвөн зуун гучин есөн мянга есөн зуун тавин дөрөв/ ширхэг “Мах” бондоос 430,921 /дөрвөн зуун гучин мянга есөн зуун хорин нэг/ ширхэг бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн барагдуулсан тул “Баян-Өлгий мах маркет” үйлдвэрийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанаас чөлөөлж, үлдэгдэл бондын /10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 9,033 ширхэг/ үндсэн болон хүүгийн төлбөрийн барьцаанд 2,218,022,100 /хоёр тэрбум хоёр зуун арван найман сая хорин хоёр мянга нэг зуу/ төгрөгийн үнэлгээ бүхий “Жаст Агро” ХХК-ийн “Хөвсгөл мах маркет” үйлдвэрийн үл хөдлөх хөрөнгийг үлдээхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Жаст агро” ХХК /Т.Содномдаржаа/, “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус даалгасугай.

2. Бондын орлогоос татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үндсэн болон хүүгийн төлбөрт холбогдох журмын дагуу үргэлжлүүлэн хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001862